



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ө.ШИЖИР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.05.21 № 118/781


танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Ашигт малтмалын тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хавсралт ²⁰... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

990255006139

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2025 оны 03 дугаар сарын 11-ны
№ 1781 тоот албан бичгийн хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ө.ШИЖИРИЙН МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Байгалийн баялгийн үр өгөөжийг нийт иргэдэд хүртээх агуулга, зорилго бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсгийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдан хэрэгжиж байна.

Үндэсний баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хөгжлийн сан, Хуримтлалын сан гэсэн 3 төрөлжсөн сантай бөгөөд Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэн ажиллахаар хуульчилсан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор баталсан. Уг журмаар Хуримтлалын сангийн хөрөнгийг иргэдийн нэрийн дансанд бүртгэх, иргэд нэрийн дансны хөрөнгийг гэр бүлийн гишүүнд шилжүүлэх, мөн Иргэний хуулийн холбогдох заалтын дагуу өвлөх боломжтой байх, Хуримтлалын сангийн хөрөнгийг 2030 он хүртэл зөвхөн хөрөнгө оруулалтад оруулан өсгөх, 2030 оноос иргэний нэрийн дансанд тодорхой хуримтлал үүссэний дараа эрүү мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар зарцуулахаар тусгасан болно.

Монгол Улсын нийт 3,565,900 иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд 138.9 мянган төгрөгийн бүртгэл хийж, И-Монгол цахим системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс иргэн өөрийн нэрийн дансны үлдэгдлийг шалгах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн орлогоос "уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг"-аас Хуримтлалын санд 499.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хуримтлалын сангийн Монголбанкн дахь төрийн сангийн дансанд 495.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 507,114.8 сая төгрөг, хүүгийн орлогоор 55 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг

санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562 тэрбум төгрөг байхаар тус тус хуульчилсан.

ХУРИМТЛАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

№	Компаниуд	2024 он (төгрөгөөр)		
		Төвлөрүүлэх орлого	Төвлрүүлсэн	Зөрүү
1	Эрдэнэс Тавантолгой ХК	200,000,000,000.0	200,000,000,000.0	
2	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	273,031,625,042.1	273,031,625,042.1	
3	Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр	13,614,960,514.7	13,614,960,514.7	
4	“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ	8,657,239,243.8	8,657,239,243.8	
5	Цемент Шохой ХХК	3,826,764,557.7		(3,826,764,557.7)
6	Эрдэнэс Оюу Толгой ХХК	342,865,122.2	342,865,122.2	
	Нийт	499,473,454,480.5	495,646,689,922.8	(3,826,764,557.7)

Асуулга 2.Ашигт малтмалын орд газарт төр өөрийн оролцоог бий болгож хувь хүртэх тухай Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.4, 5.5 дахь хэсгийн хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлаас 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4.1.12-т зааснаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг” гэж, 8.1.4-т зааснаар Улсын Их Хурал Засгийн газраас өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах, хасах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Дээрх бүрэн эрхийн дагуу “Тодорхой ордыг стратегийн ордод хамааруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 15 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан.

Мөн уг жагсаалтад Улсын Их Хурлын 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордыг нэмсэн.

Түүнчлэн, Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулийн 5.5-д “Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал

өөрөөр тогтоож болно” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр тогтоолоор Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо, Дулаан уулын ордыг эзэмшиж байгаа “Бадрах энерги” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг давуу эрхийн 10 хувийн хувьцаагаар өөрчилж, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулахаар шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 88 дугаар тогтоолын 1-д “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд даалгасугай” гэсний дагуу тус яамнаас сүүлийн 10 жилд нөөц тогтоогдсон ордуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, холбогдох санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх чиг үүргийг хариуцах Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг томилоод байна.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналын төсөл боловсруулах, энэ асуудлаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулан байгуулсан.

Асуулга 3.Ашигт малтмалын стратегийн орд газрын тоог нэмэх үйл ажиллагааг зохицуулсан Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсгийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт /Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/-аар 16 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан.

Уул уурхайн сайдын 2012 оны 85 дугаар тушаалаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах боломжтой ордуудыг судалж, санал боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус Ажлын хэсгээс гаргасан саналын дагуу Уул уурхайн яам (хуучин нэрээр)-наас Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэний дагуу 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч тогтоолын төслийг хэлэлцэх эсэх дэмжигдээгүй болно.

Жич: “Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох баримт бичгийг хавсаргав.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 88 дугаар тогтоолын 1-д “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд даалгасны дагуу сүүлийн 10 жилд нөөц тогтоогдсон ордуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, холбогдох санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Асуулга 4. Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь хэсгийн хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хилийн зурвас газрыг тогтоож, улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 81 дүгээр (маш нууцыг зэрэглэлтэй) тогтоолын дагуу улсын хилийн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд газрыг авч, газрын харилцаа болон кадастрын байгууллагын бүртгэлийн системд эргэлтийн цэгийг бүртгэсэн байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-т улсын хилийн зурваст хил хамгаалалтын зориулалттайгаас бусад барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах, газар ашиглах асуудлыг Засгийн газар шийдвэрлэхээр хуульчилсан.

Өнөөдрийн байдлаар хилийн зурвас газартай давхцалтай Ашигт малтмал, газрын тосны газрын геологи, уул уурхайн кадастрын нэгдсэн системд бүртгэлтэй хүчин төгөлдөр ашигт малтмалын хайгуулын 16, ашиглалтын 38 буюу нийт 54 тусгай зөвшөөрөлд хамаарах талбай бүхэлдээ болон хэсэгчлэн давхцалтай байна.


Дээрх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 54 аж ахуйн нэгжээс Ашигт малтмалын тухай хуульд заасан ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах хүсэлтийг холбогдох салбарын яам, агентлагт ирүүлээд байна.

Монгол Улсын хилийн зурвас дагуу ашигт малтмалын 58 тусгай зөвшөөрөл бүхий талбайд 54 орд, илрэл тогтоогдсон байна. Үүнд: алтны 26, нүүрсний 10, төмрийн 2, гянтболдын 2, цайр, мөнгө, молибдени тус бүр 1, барилгын материалын болон бусад ашигт малтмалын 11 орд, илрэл байна.

Ашигт малтмалын нөөцийн хувьд 4750 кг алтны, 1.12 тэрбум тонн нүүрсний, 19.81 сая тонн төмрийн, 2298.0 мян.тонн мөнгөний, 20.13 мян.тонн молибдени, 581.0 тонн цайрын, 3999.0 тонн гянтболдын, 193.6 сая м3 барилгын чулууны нөөц тогтоогдсон байна.


Монгол Улсын хилийн зурвас дагуу ашигт малтмалын хайгуулын 16, ашиглалтын 38 тусгай зөвшөөрөл байна (Зураг-1).

Зураг-1. Улсын хилийн 15 км-ийн зурвас дагуух ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тойм зураг



Хилийн 15 км-ийн зурваст 54 орд, илрэл тогтоогдсон байна. Үүнд: алтны 26, нүүрсний 10, төмрийн 2, гянтболдын 2, цайр, мөнгө, молибдени тус бүр 1, барилгын материалын болон бусад ашигт малтмалын 11 орд илрэл байна (Зураг-2).

Зураг-2. Улсын 15 км-ийн зурвас дагуух ашигт малтмалын тойм зураг



Хилийн 15 км-ийн зурваст 4750 кг алтны, 1.12 тэрбум тонн нүүрсний, 19.81 сая тонн төмрийн, 22.98.0 сая тонн мөнгөний, 20.13 мян. тонн молибдени, 581.0 тонн цайрын, 3999.0 тонн гянтболдын, 193.6 сая.м3 барилгын чулууны нөөц байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс хилийн зурвастай давхцал бүхий нийт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн жагсаалтыг гаргаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр яамдаас санал авах ажлыг зохион байгуулж байна.

Асуулга 5.Стратегийн орд газрыг тогтоосон, нэмэгдүүлэх боломжийг судлахыг даалгасан утга бүхий Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон стратегийн орд газрууд хэрхэн хувийн хэвшлийн эзэмшилд шилжиж очсон, стратегийн ордын тоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлууд, Үндэсний баялгийн сангийн хуримтлалын эх үүсвэрийг бүрдүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөж буй ажлын талаар

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт /Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/-аар 16 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан.

1.Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 2 дахь заалтын хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулж, үйл ажиллагаа нь зохицуулагдаж байсан дараах ордууд байна:

-Монгол Улсын Засгийн газар болон “Чинхуа-Мак-Нарийнсухайт” ХХК-ийн хооронд 2005.07.04 - 2015.07.04;

-Монгол Улсын Засгийн газар болон “Бороогоулд” ХХК-ийн хооронд 1998.07.06 - 2008.07.07;

-Монгол Улсын Засгийн газар болон “Цайртминерал” ХХК-ийн хооронд 1998.05.15-2013.05.15-ны өдрийн хооронд хугацаатай тогтвортой байдлын гэрээ байгуулсан байна.

2.Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилт: Уул уурхайн сайдын 2012 оны 85 дугаар тушаалаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах боломжтой ордуудыг судалж, санал боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус Ажлын хэсгээс гаргасан саналын дагуу Уул уурхайн яам (хуучин нэрээр)-наас Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсний дагуу 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч тогтоолын төслийг хэлэлцэх эсэх дэмжигдээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд дараах ордуудын эзэмшлийн хэмжээг танилцуулж, шийдвэрлүүлсэн байна:

-Монгол Улсын Их Хурлын 2009 оны 57 дугаар тогтоолоор Оюу толгой ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны төрийн эзэмшлийн доод хэмжээг 34 хувиар тогтоосон.

-Монгол Улсын Их Хурлын 2014 оны 54 дүгээр тогтоолоор “Цагаансуварга”-ын ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэж үзсэн.

-Монгол Улсын Их Хурлын 2016 оны 14 дүгээр тогтоолоор “Гацууртын алтны үндсэн орд”-ын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон.

Стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, хил заагийг хуулийн дагуу бүрэн тогтоож, баталгаажуулсан эсэх талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2014 онд баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дугаар заалтад “стратегийн ач холбогдол бүхий ордын хил заагийг тогтоох” эрхийг Засгийн газарт олгосон.

Үүний дагуу Засгийн газрын 2017 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар “Гацууртын алтны үндсэн орд”-ын талбайн хил зааг, 2018 оны 300 дугаар тогтоолын хавсралтаар “Нарийнсухайтын нүүрсний орд”, “Тавантолгойн чулуун нүүрсний орд”, “Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд”, “Багануурын хүрэн нүүрсний орд”, “Цагаан суваргын зэс, молибденийн орд”, “Бүрэнхааны фосфоритын орд” “Эрдэнэтийн зэс, молибденийн орд”-ын талбайн хил заагийг тус тус тогтоосон.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 88 дугаар тогтоолын 2-т “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарч байгаа хил зааг нь тогтоогдоогүй ордуудын талбайн хил заагийг тогтоох саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд даалгасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 06-ны А/77 дугаар тушаалаар үлдсэн 8 ордын хил заагийг тогтоох үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, тус 8 ордын хил заагт хамаарах тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хэлэлцээр хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамдаас санал авах ажлыг зохион байгуулж байна.

Жич: Засгийн газрын 2017 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар “Гацууртын алтны үндсэн орд”-ын талбайн хил зааг, 2018 оны 300 дугаар тогтоолын хавсралтаар хил зааг тогтоогдсон стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагт хамаарч байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх мэдээллийг хавсаргав.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрууд хэрхэн хувийн хэвшлийн эзэмшилд шилжиж очсон талаар:

Улсын Их Хурлаас 1997 онд баталсан Ашигт малтмалын тухай хуулиар хамгийн эхэнд өргөдөл гаргасан этгээдэд тусгай зөвшөөрөл олгодог байсан эрх зүйн зохицуулалттай байсан бөгөөд уг хуулийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон байдаг.

Жич: Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжийн мэдээллийг хавсаргав.

Стратегийн ордыг тоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлууд:

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтын 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн а/3444 тоотоор өгсөн чиглэлийн дагуу Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 434 тоот тушаалаар “Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан 39 ордоос стратегийн ач холбогдолтой байж болох ордуудыг үнэлж, санал боловсруулах ажлын хэсэг байгуулж, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-г баталсан.

Улмаар Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 болон 2 дугаар хавсралтад нэмэхээр “Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн ЗГ-1/75 тоот албан бичгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч тогтоолын төслийг хэлэлцэх эсэх дэмжигдээгүй болно.

Одоогийн байдлаар Засгийн газрын 2024 оны 88 дугаар тогтоолын 1-д “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд даалгасны дагуу тус сүүлийн 10 жилд нөөц тогтоогдсон ордуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийх, холбогдох санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийгдсэн ашигт малтмалын ордуудын талаар

Ашигт малтмалын тухай хуулийн 60.1-д “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газраас олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөж төлнө” гэсэн заалтыг үндэслэн Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох, төсөвт нөхөн төлөх журам”-аар улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээг байгуулан ажиллаж байна.

Нөхөн төлбөрийн гэрээ байгуулсан байдал.

1998-2016 онуудад нийт 333 тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй нөхөн төлбөрийн гэрээг нийт 47,749,189.56 ам.долларын дүнтэй байгуулж ажилласан байна. Үүнээс 253 тусгай зөвшөөрөл эзэмшигчид 30,632,638.52 ам.долларын төлөлт хийж гэрээний үүргээ биелүүлж төлбөрөө бүрэн барагдуулсан. 79 гэрээ нь тодорхой хэмжээний үлдэгдэлтэй, эдгээр аж ахуйн нэгжүүд нь зарим нь татан буугдсан, зарим нь тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан

бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд хамрагдсан, олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй хэлбэртэй байна.


Нийт нөхөн төлбөрийн гэрээний төлөлтийн мэдээлэл

Он	Нийт гэрээний дүн	Үүнээс		
		Нийт бодогдсон	Төлсөн	Үлдэгдэл
1998-2016	Ам.доллар	47,749,189.35	30,632,638.52	17,116,550.83
	Төгрөг	516,950,037.67	516,950,037.67	
2017-2023	Төгрөг	29,942,443,619.35	12,076,817,765.99	17,865,625,853.36
Нийт	Ам.доллар	47,749,189.35	30,632,638.52	17,116,550.83

---oOo---

№	Ордын нэр	Байршил		Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Эзэмшлийн хувь		Тусгай зөвшөөрлийн дугаар	Стратегийн ордны хил зааг тогтоосон байдал, Тогтвортой байдалын болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан байдал
		Аймаг	Сум		Төр	Иргэн, Аж ахуйн нэгж		
1	Таван толгойн чулуун нүүрсний орд	Өмнөговь	Цогтцэций	Эрдэнэс таван толгой ХХК	73.5	0.06 /мүрэд 26.4/	MV-016681	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Тавантолгойн чулуун нүүрсний ордны стратегийн ордны талбайн хил заагийг 81440.37 га талбайн хэмжээгээр тогтоосон.
		Өмнөговь	Цогтцэций				MV-016682	
		Өмнөговь	Цогтцэций				MV-016683	
		Өмнөговь	Цогтцэций				MV-011943	
		Өмнөговь	Цогтцэций				MV-011953	
		Өмнөговь	Ханхонгор, Цогтцэций				MV-011954	
		Өмнөговь	Цогтцэций				MV-011955	
		Өмнөговь	Цогтцэций				MV-011956	
		Өмнөговь	Цогтцэций				MV-011952	
		Өмнөговь	Цогтцэций				MV-000287	
		Өмнөговь	Ханхонгор	Хангад эжлээрйишн ХХК	0	51 /Орон нутаг/	MV-014493	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Нарийн сухайтын чулуун нүүрсний ордны стратегийн ордны талбайн хил заагийг 164933.99 га талбайн хэмжээгээр тогтоосон.
		Өмнөговь	Ханхонгор				MV-017336	
		Өмнөговь	Гурвантэс				MV-000227	
		Өмнөговь	Гурвантэс				MV-005458	
		Өмнөговь	Гурвантэс				MV-006652	
		Өмнөговь	Гурвантэс				MV-012225	
		Өмнөговь	Гурвантэс				MV-012226	
		Өмнөговь	Гурвантэс				MV-005459	
		Өмнөговь	Гурвантэс				MV-012726	
		Өмнөговь	Гурвантэс				MV-016669	
2	Нарийн сухайтын нүүрсний орд	Өмнөговь	Гурвантэс	Хүрэн толгой мсал майнинг ХХК/өмнө нь Чинхуа МАК нарийн сухайт ХХК эзэмшиж байсан./	0	100	MV-020436	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Нарийн сухайтын чулуун нүүрсний ордны стратегийн ордны талбайн хил заагийг 164933.99 га талбайн хэмжээгээр тогтоосон.
		Өмнөговь	Гурвантэс				MV-020436	
		Өмнөговь	Гурвантэс				MV-020451	
		Өмнөговь	Гурвантэс, Ноён				MV-017317	
		Өмнөговь	Гурвантэс				MV-020781	
		Өмнөговь	Гурвантэс				MV-021384	
		Өмнөговь	Гурвантэс				XV-020915	
		Өмнөговь	Гурвантэс				MV-001371	
		Өмнөговь	Гурвантэс				MV-013631	
		Өмнөговь	Гурвантэс				MV-013630	
3	Багануурын хүрэн нүүрсний орд	Улаанбаатар	Багануур	Эрдэнэс Монгол ХХК	75	25	MV-021484	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Багануурын хүрэн нүүрсний ордны стратегийн ордны талбайн хил заагийг 6394.18 га талбайн хэмжээгээр тогтоосон.
		Улаанбаатар	Багануур				MV-021484	
		Улаанбаатар	Багануур				MV-000901	
		Улаанбаатар	Багануур				MV-013311	
		Улаанбаатар	Багануур				MV-013312	
		Улаанбаатар	Багануур				MV-013313	
		Улаанбаатар	Багануур				MV-020419	
		Улаанбаатар	Багануур				MV-020420	
		Улаанбаатар	Багануур				MV-020421	
		Улаанбаатар	Багануур				MV-020423	
4	Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд	Шивээ	Овоог	Эрдэнэс Монгол ХХК	100	0	MV-000901	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордны стратегийн ордны талбайн хил заагийг 63325.05 га талбайн хэмжээгээр тогтоосон.
		Шивээ	Овоог				MV-013311	
		Шивээ	Овоог				MV-013312	
		Шивээ	Овоог				MV-013313	
		Шивээ	Овоог				MV-020419	
		Шивээ	Овоог				MV-020420	
		Шивээ	Овоог				MV-020421	
		Шивээ	Овоог				MV-020423	
		Шивээ	Овоог				MV-000901	
		Шивээ	Овоог				MV-013311	

	Говьсүмбэр	Сүмбэр, Шивээговь				МВ-020424	
	Дорноговь	Мандах	Эрдэнэс цагаан суварга ХХК	0 МУХ-ын 2014. 07. 01- ний 54 дүгээр тогтоолоор төр хувь зээмших шардлагагү й гэж үзсэн		МВ-009630	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Цагаан суваргын ордны стратегийн ордны талбайн хил заагийг 20732.5 га талбайн хэмжээгээр тогтоосон.
5	Дорноговь	Мандах	Монголын алт МАК ХХК	100		МВ-017535	
	Дорноговь	Мандах				МВ-017541	
	Дорноговь	Мандах	Тойн минералс груул ХХК	0	100	ХУ-021482	
	Орхон	Баян-Өндөр, Жаргалант	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	100	0	МВ-000011	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Эрдэнэтийн овооны эхс- молбөдний ордны стратегийн ордны талбайн хил заагийг 246504.22га талбайн хэмжээгээр тогтоосон.
	Орхон	Жаргалант				МВ-017545	
	Орхон	Баян-Өндөр, Жаргалант				МВ-020730	
	Булган	Орхон				МВ-020733	
	Булган, Орхон	Орхон, Жаргалант				МВ-021000	
	Булган, Орхон	Бутат, Сэлэнгэ, Хөвсгөл, Баян-Өндөр				ХУ-022166	
	Булган, Орхон	Орхон, Жаргалант				ХУ-022167	
	Орхон	Баян-Өндөр, Жаргалант	Орхон, Баян-Өндөр, Жаргалант	100	100	ХУ-022168	Хамжээгээр тогтоосон.
	Булган	Хөвсгөл				ХУ-022169	
	Булган, Орхон	Орхон, Баян-Өндөр, Жаргалант				ХУ-022170	
	Булган, Орхон	Орхон, Баян-Өндөр, Жаргалант				ХУ-022171	
	Булган, Орхон	Орхон, Жаргалант				МВ-001701	
	Орхон	Баян-Өндөр				МВ-000242	
	Булган	Орхон				ХУ-63000022 (ГХ-01026) түсэмэл тэрхэлтэй	
	Хөвсгөл	Түнэл	Нарангийн бутат	0	100	МВ-011823	Засгийн газрын 2018 оны 300 дугаар тогтоолоор Бүрэнхааны фосфоритын ордны стратегийн ордны талбайн хил заагийг 27393.74 га талбайн хэмжээгээр тогтоосон.
	Хөвсгөл	Бүрэнголтох	Топрунхэнцэо ХХК			МВ-011824	
	Хөвсгөл	Нороволон	Сүтэйхэнцэо ХХК	0	100	МВ-017398	
	Хөвсгөл	Бүрэнголтох	Талстмаргад ХХК			МВ-003999	
	Хөвсгөл	Бүрэнголтох				МВ-011428	
7	Бүрэнхааны фосфоритын орд	Сэлэнгэ	Мандап			МВ-000372 /Хүчингүй/ МВ-000431 /Хүчингүй/ МВ-005082 /Хүчингүй/ МВ-010810 /Хүчингүй/	Засгийн газрын 2017 оны 109 дүгээр тогтоолоор Галууртын ордны стратегийн ордын талбайн хил заагийг 3025 га талбайгаар тогтоосон.
8	Галууртын алтын орд	Сэлэнгэ	Мандап	0	100		
	Сэлэнгэ	Мандап	Сентеррагоулд монголиа ХХК зээмшиж байсан.				
	Сэлэнгэ	Мандап					
	Сэлэнгэ	Мандап					



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 13 он 05
сарын 31 өдөр

Дугаар 37-1/75


Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА


Төсөл өргөн мэдүүлэх тухай

"Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.



Монгол Улсын Ерөнхий сайд

 Н.АЛТАНХУЯГ



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2013 оны 05 дугаар
сарын 31 ны өдөр

Дугаар ... *хөг/908*


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БОЛДБААТАР ТАНАА

Тов тогтоолгох тухай

"Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамгааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлон өгнө үү.



Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.САЙХАНБИЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны сарын 8-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтуудад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай"Ашигт малтмалын тухай" хуулийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын
Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод
хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 27
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад дараах агуулгатай нэмэлт оруулсугай.

16	Хөшөөт	Чулуун нүүрс	Ховд, Дарви	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.
17	Цайдам нуур	Хүрэн нүүрс	Төв, Баян	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.
18	Гацуурт	Алт	Сэлэнгэ, Мандал	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.
19	Мушгиа худаг	Газрын ховор элемент	Өмнөговь, Мандал-Овоо	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.
20	Лугийн гол	Газрын ховор элемент	Дорноговь, Хатанбулаг	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.
21	Хотгор	Газрын ховор элемент	Өмнөговь, Цогт- Овоо, Ханхонгор	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.
22	Халзан- бүргэдэй	Газрын ховор элемент	Ховд, Мянгад	Ордын хил хязгаарыг Засгийн газраас тогтооно.


2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудын хил
хязгаарыг нарийвчлан тогтоож, ордыг иж бүрнээр ашиглах бодлого баримталж
ажиглахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

3. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлээр стратегийн ач холбогдол бүхий ордын
жагсаалтад нэмэлт оруулсантай холбогдуулан "Тодорхой ордыг стратегийн ач
холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын
2007 оны 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын дараах агуулга бүхий
заалтыг хассугай.

32	Цайдам нуур	Хүрэн нүүрс	Төв, Баян	Нөөцийн зэрэг С2-оос доош үнэлэгдсэн.
36	Лугийн гол	Газрын ховор элемент	Дорноговь, Хатанбулаг	Нөөцийн зэрэг С2-оос доош үнэлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3 ЭНХБОЛД



**ТОГТООЛЫН ХАВСРАЛТУУДАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг хэлнэ", уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т "Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар тухайн ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамааруулах", 9 дүгээр зүйлийн 9.1.4-т "Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэсэн заалтууд болон "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолын 3 дугаарт "Тогтоолын хоёрдугаар хавсралтад заасан ашигт малтмалын ордын болон энэ тогтоол батлагдсанаас хойш нөөц нь илэрсэн ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлж байхыг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай" гэсэн нь энэхүү тогтоолын төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон.

Дээрх хуулийн заалт болон Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Уул уурхайн яаманд уг асуудлаар Ажлын хэсгийг байгуулж ажилласнаар 2007 оны Улсын Их Хурлын 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батласан 39 ордоос 17, нөөц нь тогтоогдсон томоохон ордуудаас 16 ордыг эхний ээлжинд Улсын Их Хуралд танилцуулж, шийдвэр гаргуулахад бэлэн болоод байгаа байна.

Хөшөөтийн чулуун нүүрс, Цайдам нуурын хүрэн нүүрсний ордууд нь Монгол Улсын баруун болон төвийн бүсдээ томоохонд тооцогдох ашигт малтмалын ордууд төдийгүй тогтоогдсон нөөцийн хэмжээний хувьд улсын болон бүс нутгийн эдийн засагт дорвитой нөлөө үзүүлэх ирээдүйтэй юм.

Гацууртын алтын үндсэн орд нь төвийн бүсэд орших бөгөөд тогтоогдсон нөөцийн хэмжээний хувьд улсын эдийн засагт дорвитой нөлөө үзүүлэх, Монгол Улсын эрдэнэсийн санг баяжуулахад өндөр ач холбогдолтой юм.

Техник, технологийн үсрэнгүй хөгжлийн өнөө үед газрын ховор элемент нь электрон болон цахим техникийн үйлдвэрлэлийн чухал түүхий эд болох стратегийн ач холбогдолтой тул энэ төрлийн ашигт малтмалын ордуудыг ашиглахад төрийн оролцоо нэн чухал болоод байна.

Ашигт малтмалын ордуудыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулсанаар ордыг зүй зохистой ашиглахад төрийн хяналт илүү ойртох, улсын эдийн засагт орох үр ашиг болон бүс нутагт үзүүлэх эерэг нөлөөлөл нь нэмэгдэх зэрэг нь энэхүү тогтоолын төслийг боловсруулах шаардалага болсон.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төслийн тогтоох хэсэг нь 3 заалтаас бүрдэнэ.

Тогтоолын төслийн нэгдүгээр заалтад "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад нэмж тусгуулахаар нүүрсний 2, алтны 1, газрын ховор элементийн 4 ордын жагсаалтыг тус тус хүснэгтлэн заасан болно.

Тогтоолын төслийн хоёрдугаар заалтад тухайн ордуудын хилийн заагийг тогтоох, төрийн оролцооны хэмжээг тогтоох талаар тусгасан.

Энэхүү тогтоолын төсөлд тусгагдсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод нэмж хамааруулах 7 ордын 2 нь 2007 оны Улсын Их Хурлын "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 32, 36-д тусгагдсан байгаа учир зохицуулалтын давахцал, хийдлийг арилгах зохицуулалтыг 3 дугаар заалтад тусгана.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар

- Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасны дагуу Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувь, 5.5-д Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлохоор тус тус заасан.
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжих хуулийн зохицуулалттай.
- Тогтоолын төслөөр санал болгож буй ордуудыг Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод шинээр нэмж хамааруулсанаар эдгээр ордуудад эзэмших төрийн эзэмшлийн хувьцаагаар дамжуулан улсын төсөвт ихээхэн хэмжээний орлого төвлөрөх ач холбогдолтой.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Улсын Их Хурлын "Тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолын төсөл батлагдсанаар 2007 оны Улсын Их Хурлын "Тодорхой ордыг

стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай* 27 дугаар тогтоолын нэг, хоёрдугаар хавсралтад өөрчлөлт орох бөгөөд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудтай зөрчилдөхгүй болно.

УУЛ УУРХАЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

"ХИИ.ХЭЛЭЛЦЭН нь: "Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР




**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V баар
Утас/Факс: (976-51) 26-75-33, E-mail: torlog@torlog.mn
<http://www.torlog.mn>

2013.05.31 № 1/2013
төрийн 2013.05.31-ны № 1/2013

**УУЛ УУРХАЙН САЙД
Д.ГАНХУЯГ ТАНАА**

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн
төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай
хуулийн 10.15 дахь зөвлөлт үндэслэн Тогтоолын
хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их
Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.


Х ТЭМҮҮЖИН

1555

C:\Documents and Settings\user\A-S 2013.doc



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2025. 02. 28 № 01/596

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2025 оны ХЭГ/370 дугаар “Асуулгын хариу ирүүлэх тухай” албан бичигтэй танилцлаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн асуулгаас тус яамны эрхлэх асуудлын хүрээнд буюу 1 дэх хэсэгтэй холбоотойгоор дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. Тус хуулийн төсөл батлагдсанаар Ашигт малтмалын тухай хуулийн 472 дугаар зүйлд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 201.5 -д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр, Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаас бий болсон орлогыг Хуримтлалын санд төвлөрүүлж, иргэдэд тэгш, шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдах боломж бүрдэж, Хуримтлалын санд төвлөрөх орлогын эх үүсвэр нэмэгдэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн талаар: Монгол Улсын Их Хурлын “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” 02 дугаар тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Зөөвч-Овоо, Дулаан-Уулын ордуудыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан. Тус хөрөнгө оруулалтын гэрээнд Монгол Улсын Засгийн газар нь төслийн шууд үр өгөөжийн 51-ээс доошгүй хувийг хуримтлагдах дүнгээр жил бүр хүртэх бөгөөд хэрвээ Монгол Улсын Засгийн газарт хуваарилагдсан төслийн үр өгөөж нь 51 хувьд хүрэхгүй тохиолдолд “Өгөөж тохируулах төлбөр”-ийг тухай жил бүрд нэмэлтээр авахаар Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн тусгасан.



Л.ГАНТӨМӨР

250146